

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2012 оны 2 дугаар сар

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2012 оны 2 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

/тоогоор/					
№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2011-01 сар	Нэмэгдсэн	Хасагдсан	2011-02 сар
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	188			188
3	Даатгалын төлөөлөгч	2057	24 ¹		2081
4	Даатгалын зуучлагч	8	1 ²		9
5	Даатгалын хохирол үнэлэгч	9			9
6	Актуарч	13	2 ³		15
7	Бусад	12			12

Тайлант үед даатгалын компани, даатгалын компанийн салбарын тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹ Хорооны даргын 2012 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 18 дугаар тушаалаар “Тэнгэр даатгал” ХХК-ийн 24 иргэнд даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг олгосон байна.

² Хорооны 2012 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 32 дугаар тогтоолоор “Нэйшнл эженси” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

³ Хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 28 дугаар тогтоолоор “Тэнгэр даатгал” ХХК-ийн ажилтан Б. Оюун, Г. Эрдэнэ-Очир нарт ердийн даатгалын актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг тус тус олгосон байна.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2012 оны 02 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2011 оны 02 дугаар сарынхтай харьцуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :

/төгрөгрөөр/			
№	Үзүүлэлт	2011-II	2012-II
	Даатгалын нийт хураамж	2,307,587,852.0	3 837 228 132.81
	Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал		512 329 506.41

	Олгосон нөхөн төлбөр	566,584,125.2	1 090 800 968.41
	Үүнээс Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр		42 569 350.00
	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо		99
	Давхар даатгалд төлсөн хураамж	510,219,368.4	358 281 264.42
	Байгуулсан даатгалын гэрээний тоо	4,947	17315
	Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо		9840
	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо		14637
	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	22,739,296,272.2	133 586 000 000.00
	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	43,264,118.0	79 150 000.00

2012 оноос “Жолоочийн даатгалын тухай хууль” хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөрийг задалж, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын орлого, нөхөн төлбөр гэж ангилж харуулсан.

2012 оны 2 дугаар сарын байдлаар компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 1529.6 сая төгрөгөөр, олгосон даатгалын нөхөн төлбөр өмнөх оны мөн үеийнхээс 524.2 сая төгрөгөөр өсч, давхар даатгалд төлсөн хураамж өмнөх оны мөн үеийнхээс 151.9 сая төгрөгөөр тус тус буурчээ.

2012 оны 2 дугаар сард “Жонон даатгал” ХХК шинээр даатгалын гэрээ байгуулаагүй, даатгалын хураамжийн орлого болон даатгалын нөхөн төлбөргүй ажилласан байна.

Ердийн даатгалын компаниудын 2012 оны 2 дугаар сард байгуулсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Монгол даатгал” ХХК-ийн байгуулсан 133.6 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын гэрээ бөгөөд мөн тус компани хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөр болох 79.2 сая төгрөгийг олгосон байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

№	Үзүүлэлт	2011-II	2012-II
1	Даатгалын нийт хураамж	18,108,187.60	23,492,595.82
2	Олгосон нийт нөхөн төлбөр	4,740,740.00	17,193,782.00
3	Давхар даатгалд төлсөн хураамж	-	1500,000.00
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	8	5
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд	2	3

	-Байгууллагын хугацаат даатгалд	2	0
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д		-
	- Эмнэлгийн мөнгөний даатгалд		2
	-Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	1	-
	-Тэтгэврийн даатгалд		4
	-Орон сууцны даатгалд	1	-
	-Хуримтлалын даатгалд	2	3
	-Зээлдэгчийн амь насны даатгалд		
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	20,000,000.00	50,000,000.00
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	320,000.00	12510,000.00

Урт хугацааны даатгалын компанийн 2012 оны 2 дугаар сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад даатгалын хураамжийн орлого 5.4 сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 12.4 сая төгрөгөөр, давхар даатгалын хураамж 1.5 сая төгрөгөөр тус тус өсч, хамгийн өндөр үнэлгээтэй гэрээ нь 50.0 сая төгрөг, хамгийн их нөхөн төлбөр 12.5 сая төгрөг байсан байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2011-2 сар	2012-2 сар	Өсөлт бууралт
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	12,278,487.7	23 092 683.33	10 814 196.00
2	Даатгалын зуучлагчийн орлого	12,488,198.0	11 697 324.69	790 874,00
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	35	51	16
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	2,500,000,000.0	6 683 350 000.00	4183 350 000.00

2012 оны 2 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 11.7 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна. Даатгалын зуучлагч компаниудаас хамгийн өндөр дүнтэй буюу 6 683.3 сая төгрөгийн үнэлгээтэй 3.3 сая төгрөгийн гэрээг “Асимон брокерс” ХХК зуучлан борлуулсан байна.

Тайлант хугацаанд “Эм жи ай би” ХХК даатгалын зуучлалын орлого олоогүй байна. “Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Жомолхари” ХХК, “Аме” ХХК-иуд 02 дугаар сарын мэдээг ирүүлээгүй болно.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

/төгрөгөөр/				
№	Үзүүлэлт	2011-2 сар	2012- 2 сар	Өөрчлөлт
1	Даатгалын хохирол үнэлсэний орлого	2,300,414.6	5 844 500.40	3 544 086
2	Үнэлсэн даатгалын хохирлын тоо	230	275	45
3	Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	24,074,000.0	68 881 500.00	44 807 500.00

2012 оны 2 дугаар сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 143.8 сая төгрөгийн даатгалын тохиолдлын хохирлыг үнэлж 5.8 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.

Тайлант хугацаанд “Файн эстимэйт” ХХК, “Вендо”, “Мега марз” ХХК-иуд энэ сарын мэдээг ирүүлээгүй болно.

3. БУСАД

Хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 27 дугаар тогтоолоор “Ард даатгал” ХХК-ийн санхүүгийн албаны даргаар Ганхүү овогтой Баярбатыг томилохыг зөвшөөрсөн байна. Хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор “Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам” батлагдсан байна. Хорооны 2008 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д өөрчлөлт оруулсан байна.